

Төрийн өмчит эрчим хүчний компаниуд засаглалаа сайжруулах шаардлагатай байна

Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болох эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын засаглалыг үнэлэх судалгааг Нээлттэй Нийгэм Форум(ННФ) санаачлан Эрчим хүчний яам(ЭХЯ)-тай хамтран хийж гүйцэтгэсэн. Өнөөдөр (2015.10.02) засаглалын үнэлгээний дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уулзалтад ЭХЯ, Төрийн өмчийн хороо, үнэлгээнд хамрагдсан компаниудын удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон юм.

Засаглалын үнэлгээний дүнгээс үзэхэд манай улсад компанийн засаглалын зохицуулалт сайжирч, зарим ахиц дэвшил гарч байгаа ч судалгаанд хамрагдсан эрчим хүчний 13 компанийн хувьд авбал зохих 100 хувиас дунджаар 36-г авчээ. Энэ нь компанийн засаглалын талаар гарсан хуулийн заалтууд болон энэ талаар олон улсын байгууллагаас гаргасан нийтлэг зарчим хэрэгжихгүй байгааг харуулж байна. Ялангуяа мэдээллийн ил тод, нээлттэй байдал, чухал хэлцэл болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хамгийн сул үнэлгээ авчээ.



Судалгаанаас хувьцаа эзэмшигч болон компанийн хоорондын харилцаа, төрийн төлөөлөл, түүнийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан Зөвлөмж гаргаж, компани тус бүрт хүргүүлээ. Мөн энэхүү үнэлгээнд үндэслэн Төрийн өмчийн тухай шинэ хуулийн төсөлд өгөх бодит саналуудыг нэгтгэн гаргаад байна.

Эрчим хүчний компаниуд их хэмжээний өртэй, алдагдалтай ажиллаж байгаа хүнд цаг үед энэхүү судалгаанаас гарсан зөвлөмж чухал ач холбогдолтой гэж салбарынхан нь үзэж байна. Мөн ЭХЯ-аас компаниудад засаглалын үнэлгээнээс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж, цаашид компанийн засаглалаа сайжруулах чиглэлээр ажиллах даалгавар өглөө. Тодруулбал, компаниудад судалгаанаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, Компанийн тухай хуулийг нарийн баримтлан ажиллахыг үүрэг болгосон юм.



Энэхүү судалгаа нь компанийн засаглалын түвшинг тодорхойлох олон улсын аргачлал, стандартаар хийгдсэнээрээ онцлогтой. Иймд судалгааны тайлан нь эрчим хүчний салбарын компаниудын засаглалын өнөөгийн түвшинг үнэн бодитоор тодорхойлж, цаашид засаглалаа сайжруулахад нь дэмжлэг болно гэж уулзалтад оролцогчид дүгнэсэн юм.

Цаашид ННФ төрийн өмчит эрчим хүчний томоохон компаниудын төсөв, санхүүгийн ил тод байдалд мониторинг хийж, энэхүү үнэлгээгээр гарсан Зөвлөмжийг

хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Нээлттэй Нийгэм Форум